



ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 874

Шивээговь сум

Хавар, намрын нэгдсэн эргүүл шалгалт,
сурталчилгааны ажил зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.1, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Онцгой байдлын ерөнхий газрын 2022 оны “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай” 01 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/124 дүгээр захирамжийг тус тус үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг зөрчил, шар усны үер, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хүрээнд иргэдийг болзошгүй эрсдэлээс сэргийлэх, мэдлэг мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэх зорилгоор нэгдсэн эргүүл, хяналт шалгалт, сургалт сурталчилгааны ажлыг хаврын улиралд 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 06 дугаар сарын 26, намрын улиралд 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Нэгдсэн эргүүл, хяналт шалгалт, сургалт сурталчилгааны ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Бадамханд

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Л.Чанцалмаа

(Нэрт багийн Засаг дарга)

С.Отгонбаатар

(Бэхт багийн Засаг дарга)

Б.Баттүвшин

(Цагдаагийн хэсгийн зохицуулагч, цагдаагийн ахлагч)

Г.Дашдэлэг

(Мал эмнэлгийн Тархвар зүйч)

Б.Алтансүх


(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:

3. Нэгдсэн эргүүл, хяналт шалгалт, сургалт сурталчилгааны ажлын удирдамжийг 1 дүгээр, төсвийн задаргааг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Нэгдсэн эргүүл, хяналт шалгалтын ажилд шаардагдах 1,300,000 (нэг сая турван зуун мянга) төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

5. Ажлыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, тайлагнахыг Ажлын хэсгийн ахлагч (Л.Бадамханд)-д, малчид, иргэдэд чиглэсэн сурталчилгааны ажлыг эрчимжүүлэхийг (Ажлын хэсэг)-т, сумын Ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн хүч, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.



Сумын Засаг даргын 2024 оны 06 р
сарын 10-ний өдрийн 11 дугаар
захирамжийн 1-р хавсралт



НЭГДСЭН ЭРГҮҮЛ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн A/124 дүгээр захирамжийн хүрээнд байгаль орчныг хамгаалах, Гамшгаас хамгаалах, Ойн тухай хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх болон сумын хэмжээнд болзошгүй хээрийн түймэр, байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, уул уурхайн тээврийг /маршрут, даац/ хянах зорилгоор эргүүл, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, ард иргэдийг мэдээ мэдээллээр хангах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, анхааруулга сээрэмжлүүлэг өгч ажиллахад оршино.

Хоёр. Хугацаа


Хаврын нэгдсэн эргүүл, хяналт шалгалт, сургалт сурталчилгааны ажлыг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 06 дугаар сарын 26-ны өдрийг хүртэлх хугацаанд намрын нэгдсэн эргүүл, хяналт шалгалт, сургалт сурталчилгааны ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэх ба тухайн нөхцөл байдлаас хамаарч уг хугацааг өөрчилж болно.

Гурав. Илэрсэн зөрчлийг шийдвэрлэх

Нэгдсэн эргүүл шалгалтаар илэрсэн хууль бус үйлдлийг таслан зогсоож, холбогдох байгууллагад шилжүүлэн хууль тогтоомж, дүрэм журмын дагуу шуурхай арга хэмжээ авч ажиллана.

Жич: Тухай бүр маршрут батлуулан эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулан тайлагнах.

Сумын Засаг даргын 2024 оны 06-р
сарын 10-ний өдрийн 11:14 дугаар
захирамжийн 2-р хавсралт



НЭГДСЭН ЭРГҮҮЛ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ,
СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН ТӨСӨВ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Хаврын нэгдсэн эргүүл, шалгалт, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах	Шатахуун (АИ-92)	253,9 литр	2560	650,000
2	Намрын нэгдсэн эргүүл, шалгалт, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах	Шатахуун (АИ-92)	253,9 литр	2560	650,000
Нийт					1,300,000